

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (JICA/DPUB)

Мэдээллийн эмхэтгэл No.30 2019.09

Дадлагын оюутны танилцуулга (2019.09.10)



Дадлагын оюутан Мөнх-Эрдэнэ

Сайн байцгаана уу. Миний нэрийг Лхагвабямбын Мөнх-Эрдэнэ гэдэг. МУИС-ын Япон орон судлалын тэнхимийн 4-р курсийн оюутан. 9-р сарын 4-ний өдрөөс ЖАЙКА-ийн Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих техникийн хамтын ажиллагааны төсөлд сар хагасын хугацаатай дадлага хийж эхлээд байна. Улаанбаатар хотын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд

зориулсан дэд бүтэц хөгжөөгүй, ажлын байр бага гэх нийгмийн сөрөг ойлголт хандлага их байдаг гэж боддог. Тус төсөлд дадлага хийх хугацаандаа хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг нэмэгдэж, хандлага ч мөн өөрчлөгдөнө гэж бодож байна. Сар хагасын хугацаанд төслийн хамт олноосоо ихийг сурч мэдэхийн төлөө хичээж ажиллах болно.

3 дахь удаагийн DET Сургагч багш бэлтгэх сургалтын зар

DPUB төслийн зүгээс Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын Сургагч багш бэлтгэх сургалтыг 2019 оны 12-р сарын 05~19 (ажлын 11 өдөр)-ний өдрүүдэд зохион байгуулна. Хамрагдах хүсэлтэй хүмүүс төслийн фэйсбүүк хуудаснаас холбогдох материалуудыг татаж авна уу. Бүрдүүлэх материалуудыг 11-р сарын 01(Баасан)-ний өдрийг хүртэл цахимаар хүлээн авах болно.

Тавигдах шаардлага:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн байх, сургалтын дараа DET сургалтыг тогтвортой явуулах боломжтой байх.
- DET сургалтанд хамрагдаж байсан бол давуу тал болно.

DET сургалтын хамгийн сүүлийн шинэчлэгдсэн хувилбар! (2019.09.04)

8-р сарын сүүлээр Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын сургагч багш нарт зориулсан сургалт явагдлаа. Энэ удаа DET сургалтын шинэчлэгдсэн материалыг ашиглах аргын талаар суралцсан юм. DET сургалт Монголд хэрэгжиж эхлээд 3 жил болж байна. Сургалтаар орчны саад нь хөгжлийн бэрхшээлийг бий болгож буй тухай ойлголт өгөх, саадыг арилгаж хүн бүрт ээлтэй нийгмийг бий болгох үйл ажиллагааг эхлүүлэхийг зорилт болгодог. Энэ хүрээнд сургагч багш нар маань шинэ агуулгыг сургалтандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна. “Энэ зурагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үргэлж тулгардаг асуудлыг тусгажээ. Дараагийн сургалтандаа заавал ашиглаж үзмээр байна!” “Шинэ бичлэг илүү ойлгомжтой, дүрсний чанар нь ч сайн байна” гэгцгээх сургагч багш нар шинэ материалаа хурдхан ашиглаж үзэх хүсэл эрмэлзэлээр дүүрэн байв. DET сургалтанд хараахан оролцож үзээгүй, эсвэл өмнө нь хамрагдаж байсан ч бай та бүхнийг хамгийн сүүлийн шинэчлэгдсэн агуулгатай сургалтанд оролцож үзэхийг хүсч байна.



Давтлага сургалтын үеэр

**Дадлагын оюутан Мөнх-Эрдэнийн
тэмдэглэл (2019.09.12)**

9-р сарын 5. Сонгино Хайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр зочилж ярилцлага авахын сацуу СХД-ийн НДХ-ийн үйл ажиллагаатай танилцлаа. СХД-ийн НДХ-ийн дарга Б.Жаргалсайхан биднийг найрсгаар хүлээн авч үйл ажиллагааныхаа талаар дэлгэрэнгүй ярьж өглөө. Тус хэлтэс нь ХБИ-дэд зориулж Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн



Жаргалсайхан дарга хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг танилцууллаа

хөгжлийн төвийг тохижуулсан бөгөөд энэхүү төв нь ХБИ-ийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг явуулах таатай орчинг бүрдүүлснээс гадна тус төв дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээлэл түгээх арга хэмжээ зохион

байгуулдаг талаар ярьж байсан юм. Ярилцлага өгсөн ажилчид ч мөн ХБИ-тэй харилцах, мэдээлэл хүргэх тал дээр олон ажил зохион байгуулж буй талаар ярьж байлаа. Тус хэлтсийн ажил нь үлгэр дуурайлал болохуйц гайхалтай ажил байлаа. Цаашдын үйл ажиллагаанд нь амжилт хүсье. Биднийг халуун дотноор хүлээн авч уулзсанд талархал илэрхийлье!

**JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE дарж
нэгдээрэй!!**

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **5557** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

Чадвар дутагдсан нь



Ахлах зөвлөх Чирба

APCD-д олон ажлыг амжилттай хэрэгжүүлсэн боловч нөгөөтэйгүүр зарим үйл ажиллагаанууд амжилттай бололгүй хэд хэдэн удаа сэтгэлээр унаж байв. Хөгжлийн бэрхшээлийн салбар дахь мэдлэг, туршлага дутмаг гэдгээ мэдэрсэн 5 жил байлаа. Олон ч хүмүүстэй уулзаж зөвлөгөө аван, өөрийнхөө хэмжээнд сурч судласны хүчинд ямар ч л байсан хариуцсан ажлуудаа гүйцэтгэж байсан боловч ийм чадвартайгаар цаашид ЖАЙКА-д мэргэжилтнээр ажиллах нь хэцүү юм байна гэдгийг мэдэрч байв. APCD-ийн ажил ч дуусах дөхөж, дараагийн ажлаа бодох шаардлагатай болсон үед ЖАЙКА-аас өөр газар ажиллаж үзэхээр шийдсэн юм. Шалтгаан нь ердөө л “чадвар дутагдсан”-ых байлаа. Гэхдээ цаашид юу хийх вэ...? Энэ бүхэн НҮБ-д ажиллах хүсэлтэйгээр компаниасаа гараад яг 10 жилийн дараа болсон юм. Гэхдээ миний хувьд цаашид юу хийх талаараа бодох сайхан завшаан болсон. Аз болоход НҮБ-д ч ажиллаж, ЖАЙКА-д ч мэргэжилтнээр 5 жил ажиллаж үзээд байлаа. Цаашид юу хийх вэ гэсэн ч хөгжлийн бэрхшээлийн салбарт ажиллахаас өөр сонголт байсангүй. Тэр үед APCD-ийн үйл ажиллагаагаар дамжуулан Япон сан гэдэг байгууллагыг мэддэг болоод байлаа. Япон сан нь Японы хамгийн том санхүүжилтийн сан бөгөөд хөгжиж буй орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үйл ажиллагаануудыг ч явуулж байлаа. Энд бол арай өөр аргачлалаар хөгжлийн бэрхшээл, олон улсын хамтын ажиллагааны ажил хийх боломжтой юм байна хэмээн бодож Япон санд ажил орох өргөдөл өгөв.

DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: [https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Цахим хуудас: [https:// www.jica.go.jp/project/ mongolia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html)

И-мэйл: dpub.jica@gmail.com